



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 14

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3 , аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газарт Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн санхүүжилт, орон нутгийн оролцооны хөрөнгөөр 7 нэр төрлийн 84 ширхэг 35,907,240 /гучин таван сая есөн зуун долоон мянга хоёр зуун дөч/ төгрөгийн хавсралтад заасан хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.


2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтад дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ОД-ЭРДЭНЭ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын  
22-ний өдрийн 12/1 тогтоолын хавсралт



Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын үндсэн хөрөнгөд  
бүртгэх хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Балансын үнэ
1	Палк метр /бод/	ш	20	170,000	3,400,000
2	Палк метр /бог/	ш	20	165,000	3,300,000
3	Лент метр	ш	20	65,000	1,300,000
4	Бод малын пүү	ш	1	4,007,240	4,007,240
5	Зохиомол хээлтүүлгийн иж бүрэн багаж /бог,бод/	и/б	2	2,450,000	4,900,000
6	Циркул	ш	20	175,000	3,500,000
7	Явуулийн функт	и/б	1	15,500,000	15,500,000
7	Нийт		84		35,907,240